

Монгол бөхийн хоч нэрийн тухай

И. Саруул, Э. Жигмэддорж (МУИС)

Хоч нэр гэдэг дэлхийн бүх ард түмний дунд байдаг нийтлэг үзэгдэл. Монголчуудын хувьд дэлхийн нийт ард түмний дунд байдгийн адил аливааг хочлон нэрлэх явдал бий. Энэ нь Монгол угсаатны нийгэм ахуйн харилцаанаас шалтгаалан бусад улс түмнийхээс өвөрмөц онцлогтой.

Монгол хүний хоч нэр, түүний бусад орноос ялгагдах нэгэн зүйл бол *Монгол бөхийн хоч нэр* юм. Энэ нь сонирхууштай, судлууштай сэдэв болно. Бид энд Монгол бөхийн хоч нэр, түүний онцлог болон ангиллын зарим асуудлыг хөндөж байна. Нийт 160 гаруй бөхийн 170-аад тооны хоч нэр, тэдгээрийн тайлбарыг хамааруулан үзсэн юм. Он цагийн хувьд зөвхөн XX зууны хүрээнд хязгаарласныг тэмдэглэе.

Манай ард түмэн бөхөө дээдлэн хүндэтгэхийн сацуу тухайн бөхөд ямар нэгэн нэр хоч тогтоон өгдөг заншилтай ажээ. Уг нэр хоч нь ихэвчлэн тухайн бөхийн бахархал, алдаршсан нэр болж ард түмний дунд түгэн тархаж байсан явдал нь түүхэн сурвалж, аман яриа, домог зэргээс мэдэгдэж байна.

Монгол бөхийн тухай судалгаа шинжилгээний бүтээл нилээд гарч нийтийн хүртээл болсоор ирсэн нь нэн сайшаалтай, бахархууштай. Харин тэдгээрт Монгол бөхийн хоч нэр-ийг тусгасан, тусгай судалгааны бүтээл харахан байхгүй байна. Тэгэхдээ судлаачдын бүтээлд бөхийн хоч нэрийн талаар тусгайлан судалгаа хийх шаардлага тулгараад байгаа болон түүний ач холбогдол хоч нэрийн судалгаа эхлэл төдий учир шийдвэрлэгдээгүй асуудлууд хуримтлагдсаныг тэмдэглэсэн нь цөөнгүй байгаа юм (23.т.7).

Монгол бөхийн хоч нэрийг агуулгын утгаар нь: 1. Биеийн онцлог байдал, 2. Барилдааны арга барил, 3. Төрлөх нутгийн эх сурвалж бүхий гэж болмоор байна.

01. Биеийн онцлог байдал бүхий хоч нэр :

А) Тухайн бөхийн гаднах төрх байдлаар нь:

Гилжгий - Балжин заан (17.т.48.), *Мэнгэт* – Цэрэндаш начин (11), *Хулгар (Гонжоон)* – Мэндийн Гонжоон заан (17.т.159.), *Эруу* -

Гүндмаагийн Пэрэнлэй заан (43.т.164.) Түүнийг Мөөөө аварга "Пэрэнлэй заан засуул дээр гарахгүй шүү, сүр жавхаагүй жаахан харагдуулаад болдоггүй юм" гэж байсан гэдэг, **Сахалт** - Ванчигжав заан (17.т.171.), **Гулзгай** - Учралын Дамчаа арслан (17.т.173.), **Хөнхөр** - Дэндэв заан (17.т.190.), **Арзгай (Жамьян)** - Санжидын Цамба начин (16), **Бүрхэг** – Дэндэв заан (15.т.187.), **Хавтгай** - Дашдэлэгийн Даржаа начин (16.т.224.), **Арзгай** – Санжидын Жамба начин (16), **Нахиу** – Шагдарын Санжсүрэн арслан (17.т.170.), **Нахиу** – Дугарын Гонгор заан (17.т.170.), **Халцгай** - Хайдав начин (16.т.224.), **Монхор** - Түдэвдаваагийн Самдан начин (17.т.175.), **Хавчиг** - Лувсан начин (5.т.81.), **Хулгар (Дэндэв)** - Вандангийн Дэндэв заан. Түүний өвөг эцэг "Хавчиг эрээн" гэх хочтой явсан бөгөөд богдын даншиг наадамд долоо давж заан цол хүртэж байжээ (сонин 4), **Майга** - Дэндэв заан (16.т.250.) Тэрбээр нилээд майгадуу, нэг их өндөргүй ч биеийн хүч чадал ихтэй хүн байсан тухай нутгийн хөгшчүүл одоо болтол дурсан ярьдаг. Түүний дүүг "ганган" Дэндэв гэдэг байсан бөгөөд нэг гэрийн ах дүү хоёрыг хооронд нь ялгахын тулд зааныг ийнхүү нэрлэдэг байжээ, **Хамуут** - Лувсанцэрэн, **Падигар** - Сандуй заан (16.т.250.), **Хулгар (Нацаг)** - Дашийн Нацаг заан (8.т.170.), **Эрээн хавирга** – Баатарын Төрбат арслан (5.т.85.), **Бүдүүн гуят** - Мөнхийн Загдсүрэн начин. МБАТ-ын 7-р спартакиадын үндэсний бөхийн барилдааны үеэр бөхчүүдийн биеийг хэмжижээ. Ингэхэд Д. Хадбаатар аваргын гуяны булчин тойргоорой 94 см, харин Загдсүрэн начных 93 см байсан гэдэг. Аврага Хадаатай харьцуулахад жижиг биетэй түүний гуяны булчин ийм том байсан тул энэ үеэс түүнийг ийнхүү хочлох болжээ (1.т.76.), **Мээтэн** - Ономжавын Аюур арслан (17.т.160.) "Мээтэн" хэмээх хоч нь ямар утга учиртай болох талаар судалгаа тедий л хийгдээгүй бөгөөд бичиж тэмдэглэж үлдээсэн зүйл ховор байна, **Урт гарт** – Маамын Лхагвасүрэн арслан. Тэрбээр өөрийнхөө хэрхэн хочтой болсон тухай "Урьд Аюур арслан гэж байлаа. Улсын наадамд намайг нэг амлаж авсан юм. Хаанаас нь ч барихын аргагүй, эрчээрээ дайрахад нь сандрахдаа сөрөөд сүйлсэн юм. Тэр үед Аюур гуайн тахиманд хүний гар хүрээгүй явсан юм уу даа, түүнээс хойш л намайг урт гарт Лхагва гэдэг болсон юм шүү" хэмээн хуучилсан байдаг (33.т.52.) ажгуу.

Б) **Арьсны өнгө, зүс царайгаар нь:**

Яагаан – Нямын Самдан заан (17.т.162.), **Шар** – Батжаргалын Яндаа арслан (17.т.165.), **Цоохор** – Жаргалын Дорж заан (16.), **Хар** – Дугарсүрэн заан (сонин 8), **Хүдэр Хөхийнхөн** – Хорлоогийн Баянмөнх аваргынханыг ийнхүү нэрлэдэг тохиолдол бий (15.т.273.), **Хадагт хар** – Дандаагийн Ренчиндорж заан (17.т.168.), **Хумбаа хар** – Лхамжавын Балсан арслан (12), **Буурал** – Баянмөнхийн Жамьянжав начин (17.т.208.), **Улаан** – Жамсрангийн Шарав заан (17.т.208.), **Дарин цагаан** – Дарьзавын Ванчинсүрэн заан (16.т.32.) Дарин цагаан хэмээхийн "Дарин" гэдэг нь түүний аав Дарь, харин "цагаан" гэдэг нь зааны нүүр царайны өнгө өөрөөр хэлбэл гадаад төрхийг заасан хоч нэр бололтой, **Ар худрагын цагаан** – Цагаан банди арслан. Энэ нь тухайн нутгийн бөхчүүд даншгийн наадамд явчихаар эзгүйчлэн түрүүлээ гэсэн шог яриа байжээ (15.т.79.), **Мэнгэт хар** – Д. Цэрэндаш начин (10.т.10.), **Улаан хүзүү** буюу **Угсраа** - Хүрлийн Дэлэг арслан. Тэрбээр залуудаа лам явсан бөгөөд муруй захтай дээл өмсөж, хүзүү нь үргэлж ил, наранд

түлэгдэж улайсан явдаг байснаас уг нэрийг авчээ. Харин төрсөн нутагт нь түүнийг Өөлдийн Дэлэг хэмээн нэршсэн (5.т.24.), **Хангалын хар** – Дагва арслан (8.т.178.) Хангал гэдэг нь түүний төрсөн газар, хар гэдэг нь гадаад төр байдлыг хэлжээ. Түүнийг мөн **Худрага Даваг** ч гэдэг гэх мэт.

В) Зан авиртай нь холбоотойгоор:

Агсам хүрэн - Чимэдцэрэн заан (8.т.249.), **Гуриа** –Лувсанчимэдийн Сосорбарам арслан (8.т.259.), **Аат** – Довчингийн Лувсанжамц арслан. Тэрбээр аатай, бянтай гүндүүгүй Монгол эр байжээ. Аймгийн наадамд түрүү бөхийг нанжин гахай гөлмөөр шагнахыг сонсоод замдаа гөлөм авч тохоод, эргэж ирэхдээ шагналын гөлмөө өгнө гээд хэлсэн дээ хүрч байсан зэрэг олон баримт бий (5.т.44.), **Мангар** – Цэрэндонойн Санжаа заан (17.т.191.) мөн **Том** ч гэдэг билээ.

Г) Бөхийн овор хэмжээнд нь таацуулан:

Жаахан Дамбий – Дампил арслан (8.т.217.), **Авдар** – Санжаа начин (тэмдэглэл 3), **Пандаан** – Дармын Жамьяншарав заан (16.т.34.), **Ханхар** - Лхамжав начин (тэмдэглэл 3), **Түнтэн** – Нямаахүү арслан (6.т.15.), **Махан** – Гончигын Сундуй заан (16.т.175.), **Жаал** – Дэндэв заан (8.т.189.) Түүнийг ийн нэрлэсэн нь өөрийнх нь биеийн онцлог өөрөөр хэлбэл жаахан, жаалхан гэдэгээс үүдэлтэй бололтой, **Тарган** – Санзай арслан (6.т.13.) Тэрбээр их хүчтэй, бүдүүн биетэй бөх байсан гэдэг. Тиймээс ч түүнийг биеийн ерөний байдал, хэлбэр төрхөөр нь ийнхүү хочлох болсон бололтой, **Өндөр Гонгор** - Пүрэвийн Гонгор начин (8.т.225.) Тэр зөвхөн ар Монголд төдийгүй дэлхийд гайхагдсан өндөр хүн байсан тул ийн нэрлэгдсэн ажээ, **Их Сандуй** – Сандуй заан (17.т.250.), **Бага Сандуй** – Ламжавын Сандуй заан (17.т.250.), **Бүдүүн** – Ламжав начин (3.т.239.), **Их Шарав** – Шарав заан (4.т.294.), **Хүдэр Гомбо** – Гомбо аварга (8.т.124.), **Их Гомбо** – Гомбо арслан (8.т.230.) зэргийг дурьдаж болох юм.

Д) Эрхэлдэг ажил, онцгой үйл явдлаас үүлдэлтэй:

Ангуучин – Б. Адьяахүү начин (Сонин 1.), **Хуягт хорооны** - Дамдин начин (17.т.167.), **Морин заводын** – Бямбын Балдир начин (17.т.180), **Хуягт хорооны** – Цэнд начин (17.т.167.), **Корпусын** – Дандарын Санжаа заан (16.т.38.), **Цэргийн** – Санжмятавын Шагж начин (16.т.42.), **5-р Дивизийн** – Хас-Очирын Өлзийсайхан арслан (8.т.202.), **Тусгай хорооны** – Нэмэхийн Сундуй начин (17.т.56.), **Ерөнхий** – Дашийн Самбуу арслан. 20 настайгаасаа цэргийн ерөнхий сургуулд суралцаж, улмаар сургуулдаа ажиллаж байсан тул ийн нэрлэгдэх болжээ (1.т.126.), **Цагдаа** – Долгорын Содном заан. 1902 оноос 15 – ны морьт цагдаа байгаад 1921 оны дунд үеэс ардын засгийн цагдан сэргийлэх салааны даргаар томилогдон ажиллаж байсан тул ийнхүү нэрлэгджээ (1.т.129.), **Бууч** - Омбойн Дугар аварга Тэрбээр нутаг хошуундаа гайхагдсан сайн анчин байжээ.Бага гахай, зээр зэрэг гол төлөв турган ан агнадаг тун мэргэн бууддаг тул ийн нэршсэн гэдэг (1.т.57.), **Нисэхийн** – Пагмын Аюуш арслан. Тэрбэр нисэхийн цэргийн ангид хугацаат цэргийн алба хааж байхдаа тэмцээн наадамд барилдаж аварга арслангуудыг айлгадаг болсон тул ийн хочлогдох болжээ (1.т.17.), **Хонь хавахдаг** -

Өлзийсайханы Эрдэнэ – очир арслан. 1970 аад оны үе гэдэг. Мөөөө аваргад Эрдэнэ очир арслан шавь орж нэг удаа тарваганд явжээ. Тэр үдийн хэрд хавхаа тавьчихаад ирж гэнэ. Орой нь "Миний хавханд тарвага орчихлоо" гэж их л хөөрөн дурандсанаа "ээ, балар аа" гээд л сүйд майд гүйгээд явчих нь тэр. Харин Эрдэнэ очир арслангийн хавханд тарвага биш хажуу айлынх нь хонь орсон байжээ. Энэ явдлаас хойш түүнийг ийнхүү нэрлэх болсон гэдэг (сонин 5.) юм.

Е) Ямар нэг юмтай зүйрэлсэн буюу аливаа амьтны нэрээр хочилон нэрэлсэн ;

Ишгэн – хэмээх Ганбат заан. Энэ нэрийг түүний ах нь бага байхдаа өгсөн гэдэг, **Азрага** – Сэнгэдондогын Лхагва начин. 1960 - аад оны дундуур С. Цэрэн аварга нэг өдөр дараалан болсон 2 барилдаанд Лхагва начинг амлаж аваад харцагдаж дайрах мэхэнд нь унажээ. Тэгээд Цэрэн аварга "Энэ Лхагва чинь намайг азаргын хүчээр дайраад хоёр хаячихлаа" гэснээс хойш бөхчүүд түүнийг азрага хэмээн хочлох болжээ (1.т.85.), **Аваргын зулзага** – Жигмэдийн Оргилболд начин. Хадбаатар аварга шоронгоос гарсныхаа дараа Төв аймагт болсон нэгэн барилдааны гуравын даваанд түүнд уначихаад "Падигар том биетэй ч насаар бага чамд аваргын зулзага гэсэн нэр өгье" гэсэн гэдэг (1.т.113.), **Чапаев** – Нэмэхийн Дашзэвэг начин. Тэрбээр 1959 онд болсон МЗО – ны анхдугаар их наадмын үндэсний бөхийн барилдаанд оролцож 18 давахдаа их тод өнгийн нөмрөгтэй барилдсан тул үеийнхэн нь "Чапаев" хэмээх хоч хайрлажээ (1.т.59.), **Пионер** – Бадам заан. Энэ нь Ардын хувьсгалын 40 жилийн ойн наадамд 2, 3 давсан пионер сурагчдыг амлан авч, цувруулан хаяснаас үүдэлтэй хоч, хошигнол хоёр үндэстэй гэдэг (10.т.20.), **Чоно** – Лувсангийн Энхбаяр начин. Нэг удаа түүнийг Дарханд бэлтгэл хийж байхад эхнэр нь төрж хот руу буцхаар болжээ. Нэг найз нь шөлний амьд хонь өгсөн бөгөөд түүнийг нь шуудайнд хийж мөрөн дээрээ тавин вокзал руу яваж байхдаа яг л хурга нуруундаа шидсэн чоно шиг харагдсан гэх яриа бий. Мөн тэрбээр чоно мэт хийморлог барилдаантай нэгэн билээ (сонин 8.), **Нохой** – Гомбо заан. Түүний тухай Ж. Дамдин "Гомбо нь хүнд орохдоо гайхалтай сайн бөгөөд ан хөөгөөд багалзуурт нь шургаж байгаа нохой мэт шалмаг ордог тул хүмүүс түүнийг тийнхүү нэрлэсэн" гэжээ (8.т.242.), **Мойл** – Эрдэнийн Зундуй заан (17.т.170.), **Хэрээ** – Д. Дэмбэрэл начин (17.т.156.), **Вепрь** буюу **Бодон** – Ц. Бэгзсүрэн начин (Сонин 2.), **Буур** - Цамба начин (19.т.26.), **Довцог** – Бямбын Пүрэвжав заан (15.т.111.) Пүрэвжав зааны төрсөн дүү Долгор "Миний ахыг хөмсгөө зангидахад хөмсөгний хоорондох духны арьс нь товойдог байлаа. Тиймээс Довцог гэж нэрлэсэн" хэмээн хуучилж байжээ, **Хурган Дэмид** – Жамбалын Дэмид заан (15.т.39.) Заан өөрөө нилээд биеэрхүү боловч тухайн үеийн ханд чин вангийн бөхчүүдийг бодвол бага байснаас энэхүү хочийг авсан бололтой, **Боохой** – Дамдинсүрэнгын Данзан арслан (9.т.10.), **Буханхүү** - Агнайн Моломжамц заан (8.т.177.), **Тэмээ өргөдөг** – Бямбын Жамьяндорж аварга (тэмдэглэл1.), **Пүг** - Содвын Жамьян заан (17.т.209.), **Гарьд** – Хэхрэнгийн Жамц арслан (6.т.5.), **Ишгэн** - Чойндон заан. Түүнийг мөн "Гогцоо", "Бусгаа" гэдэг (6.т.24.), **Морьт** – Пүрэв начин (тэмдэглэл 3) гэх мэт.

2. Барилдааны арга мэхтэй холбогдолтой нэр.

Энэ нь тухайн бөхийн гол мэх, барилдааны онцлогтой холбогдолтой хоч бөгөөд ихэвчлэн алдаршуулж, хүндэтгэсэн чанартай уламжлагдан ирсэн байна.

А) Бөхийн гол мэхээр нь:

Өмсдөг – Цанлигийн Дамдиндорж арслан (17.т.189.), **Шигшээ** – Шаравын Галсан начин (15), **Цахилгаан** – Мөнхөө начин (1), **Таехай** – Дашийн Лувсан заан (8.т.227.), **Тонгороо** – Чойжилын Бээжин аварга (8.т.279.), **Дүүгүүр Гомбо** – Дандрын Гомбосүрэн начин (тэмдэглэл 2.), **Дүүгүүр** – Мягмаржавын Болдбаатар начин (1.т.32.) буюу "Булганы хоёр Дүүгүүр" ч гэдэг, **Суудаг** – Цэндийн Содов арслан (17.т.168.) Хүнтэй барилдахдаа гол төлөв сууж өрдөг учир ийнхүү нэршжээ, **Гүйдэг** – Тэрбишийн Сүрэнжав заан (17.т.172.), **Гүйдэг** – Ширчингийн Даш заан (15.т.227.) Тэрбээр барилдаан сайтай, хурдан шалмгай, орох мэхийг гойд сайн эзэмшсэн, гүйх мэт барилддаг байсан учир олноо ийнхүү алдаршжээ, **Гуяддаг** – Дармын Жамьяншарав заан (8.т.178.) Бөхчүүлийн ярих нь түүний дүүгүүрдэж гуядах нь бүр ч хэцүү гэдэг. Тиймээс энэ нэрийг авсан бизээ, **Хөл** – Бат-Очирын Пүрэвдорж начин. Судлаачдын бичсэнээр тэрбээр хөлөө алдаад ер унадаггүй, хөлөө өгч дагуулж гуядах, цохих, хутгах мэхийг гарамгай сайн хийдэг байжээ (15.т.196.) гэх мэт.

Б) Барилдааны онцлогоор нь:

Накад – Цэдэндамбын Баярсайхан заан (1.т.27.), **Уран цагаан** – 3. Чинбат начин (11.т.13.), **Хөндлөн** – Дашийн Сандуйжав заан (17), **Мундаг** – Цэдэнгийн Лувсандаш арслан (7), **Солгой** – Сандуй заан (сонин 8.), **Дүүлэн Чүлтэн** – Гомбожавын Чүлтэм начин (16), **Гүүвц** – Пунцагын Сүхбат заан, **Годон** – Равдангийн Дампил арслан. Бидний бодоход уг хоч түүний өөрийнх нь барилдааны онцлог, мэхийн хувилбар, годогносон түргэн хөдөлгөөнтэйгээс үүдэлтэй байж тун магадгүй, **Молиг бүргэд** – Пэлжээгийн Бат-очир арслан. Түүний тухай улсын заан цагдаа хэмээх Содном "Бат-очир бол бүргэд шиг нэг их сайхан молилзоод гардаг байсан болоод молиго бүргэд нэрийг авсан юм" хэмээн дурсан ярьжээ. Төв аймгийн Дэлгэр хаан сумын төвд түүний дурсгалд зориулсан хөшөөний бичээст "Молиго бүргэд" хэмээгдэх гэсэн байгаа нь түүний ард түмнийхээ дунд ямар нэр хүндтэй байсаны нэгэн илэрхийлэл мөн (тэмдэглэл 2), **Самарган цагаан** – Ёндонжунай арслан (14.т.44.) Арсланг өөрийх нь дархан мэхээр өөрөөр хэлбэл өрсөлдөгч бөхийг самууруулах, самгардуулан өвдөг шороодуулах чадвараар нь хочлох болсон мэт, **Мундаг** – Гонгорын Наваан заан. Цэвэлийн толинд Мундаг хэмээх нь сүрхий, бузгай, лут, мундаг сайхан зэрэг утгыг илэрхийлнэ гэжээ (18.т.350.), **Уран гараат** – Гүнсэнгийн Баттогтох начин. Түүний барилдахаар гарах, дэвэх, шавах нь үнэхээр сэтгэл хөдлөм уран гоё харагдаг байсан гэдэг (1.т.25.). Энэ мэт жишээ олон буй.

В) Хүндэтгэлийн чанартай:

Чой – Цэдэнжавын Чойжамц начин (1), **Өвөө** – Өвгөнхүү начин (сонин1), **Лундаа** – Лундаажанцан арслан (16), **Сөөлөнгөө** – Лувсанмөрийн Ёндон

заан (16), **Гарам заан** – Дэмидийн Гарамбазар заан (17.т.173.), **Данигай** – Гэлэгийн Дайнаа начин (17), **Гомбо аварга** – Шагдарын Лувсанжамц аварга (8), **Арван засгийн** – Сугар заан (17.т.250.), **Жонго** – Дэндэвийн Даваасүрэн заан (17.т.178.), **Дэдийн Жамц** - Чимэг - Очир арслан (16.т.4.), **Шинэ Жамц** – Сандаг - Очир арслан (6.т.6.), **Данигай** – Дугаржавын Дамдин заан (17.т.111.), **Босоо (Жаахан)** – Дамбий арслан (8.т.79.), **Ерөнхийлөгчийн бөх** – Жанцангийн Чулуун начин (1.т.67.), **Маршалын бөх** – Б. Түвдэндорж аварга (1.т.88.), **Унгар** – Эрдэнэбилэг начин (10.т.17.), **Их монгол** – Хасын Шаравжамц аварга, **Босоо Самдан** – Ганжуурын Самдан аварга. Тэрбээр нутаг хошуу, аймаг, шавийн олон наадамд босоо үлдэж явсан, Сэцэн ханы нэгэн цуут бөх ажгуу (17.т.238.), **Босоо Шагдар** – Сосорын Шагдар арслан. Арслангийн аав Сосор нь “Жоомоо” хэмээх хочтой явсан гэдэг. Ийнхүү эцэг хүү 2 хоёулаа хочтой байгаа нь Монгол бөхийн түүхэн дэхь цөөхөн тохиолдлын нэг юм (8), **Босоо Банзар** – Баясахын Банзар арслан (15.т.148.) Тэрбээр хойч үеийнхэндээ “Сайн бөх гэдэг нь сайхан бөхөөсөө ялгаатай, сайхан бөх гэдэг нь бие цогц юм. Сайн бөх гэдэг нь барилдааны арга зүйг эзэмшсэн, түргэн шаламгай барилддаг, даацтай мэхтэй бөхийг хэлнэ” хэмээн сургамжилж байснаас үзэхэд тэр аргагүй Халхын дэвжээнээ босоо заяатай төрсөн арслан байжээ, **Булган сүүлтэй бөх** – Улсын цол хүртсэн бөхийн араас нутаг уснаас нь олон сайхан хүчит бөх төрөн гарвал анх түрүүнд цол хүртсэн бөхийг ийнхүү нэрлэдэг. Тухайлбал; М. Цэрэндорж, Т. Нармандах нарыг булган сүүлтэй начин гэдэг (1.т.41.), **Америк** – Агваан Норов начин. 1975 онд АНУ – ын Толида хотноо болсон дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон. Норов начин тэндээс жинсэн өмд, кобой малгай худалдан авч нутагтаа ирээд түүгээрээ байнга гангарах болсон тул нутгийнхан нь ийнхүү хочлох болжээ (1.т.112.) гэх мэт.

3. Газар нутгийн сурвалж бүхий.

Энэ нь бөхийн хоч нэрэнд нилээд хувийг эзлэх бөгөөд мөн ихэвчлэн хүндэтгэсэн чанартай хэрэглэгдэж иржээ. Өнөө үед тухайн бүх өөрийн нутаг усаара цоллогдон буй нь үүний улбаа гэж үзэж болох юм.

Газар нутгийн сурвалж бүхий хоч нэрийг он цагийн хувьд авч үзвэл:

А) 1900 – 1920 - иод оны буюу ХХ зуны эхэн үеийн:

Луу Гүний – Вандан аварга (17.т.157.), **Их Шавийн** – Самдан арслан (17.т.157.), **Арцат** – Уламбаяр арслан (6.т.7.), **Шавийн Гомбо** – Гомбо заан (8.т.129.), **Баруун Гүний их Шарае** – Шарав заан (7.т.294.), **Баргын** – Шагдарын Гилэг арслан (8), **Гандангийн Бүрхэг** – Гунгаагийн Намжилваанчиг арслан. Тэрбээр гандан хийдэд шавилан сууж байсан бөгөөд нүдний хараа муу алсын юмыг төдий л хардаггүй зэргээс түүнийг ийнхүү нэрлэжээ (15.т.173.), **Ялгуусны** – Насангын Вандан заан. Зааны энэхүү тодотгол нь түүнтэй нэгэн үе барилдаж, алдар нэрээ дуурсгаж явсан Вандан аваргаас ялгахын тулд шавилан сууж байсан хийдийх нь нэрээр нэрлэсэн гэдэг (1.т.46.) билээ.

Б) 1930 аад оноос 1990 он.

Увсын дөрвөлжин хар – Одвогын Балжинням аварга, **Ерөөгийн Хөх** – Балдан заан (13.т.27.), **Дорнодын Хумбаан хар** – Лхамжавын Балсан арслан (16), **Мөнгөн морьтын** – Лувсанмөрийн Чимэд арслан

(16), *Ареай хээрийн Банди* – Цэдэвийн Банди арслан (17.т.158.), *Нисэхийн* – Дашийн Лувсан арслан (17.т.183.), *Ареай хээрийн Цоодол* – Цоодол арслан (16.т.158.), *Хөөсгөлийн хужаа* – Өлзийтийн Чүлтэмсүрэн арслан. Арслан бага балчир насандаа эхээсээ өнчирч “Донир” гэдэг хочтой ах ламынхаа асрамжинд Дэлгэр мөнхийн хүрээнд амьдарч байсан бөгөөд түүнийг хужгар шар царайтайд нь “Хужгар” гэж хочилж байжээ. Тэр нь улмаар “Хужаа” болон дуудагдах болсон юм гэдэг (5.т.172.), *Баянхонгорын том гуталт* – Пүрэжавын Нямжанцан начин. 1959 онд МЗО – ны анхдугаар их наадамд ирж барилдахдаа татгардуу ногоон зодогтой, гарын эсгийгээр хийсэн далбагар оймстой, том монгол гутал өмссөн байсан тул олноос ийм алдар гуншин хүртжээ (1.т.113.) гэх мэт.

В) 1900- оноос хойш үе.

Монгол улсад ардчилал хөгжин хүний эрх, эрх чөлөөг дээдлэх болсон билээ. Үүнтэй холбоотойгоор тухайн бөх ямар нэг ивээн тэтгэгч байгууллага, клубын нэрийг хэрэглэх хандлага нилээд ихссэн байна. Тухайлбал; *Буян компаний буян дэвжээний* – А. Сүхбат аварга, *Авзага трейдын* – И. Доржсамбуу заан, *Бага нуур хувцаат компаний* – Бумбаяр заан, *Оюуны ундраа компаний* – Баянмөнхийн Гантогтох заан, *Эрэл компаний “Эрэл” дэвжээний* – Долгорсүрэнгийн Сумьяабазар заан, *Бриж группын бөх* – Гэлэгжамцын Өсөхбаяр арслан, *Алдар нийгэмлэгийн* – Ганбат заан, *Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” нийгэмлэгийн* – Бадмаанямбуугын Бат-эрдэнэ аварга, *Автобус III компаний бөх* – Цэвээн начин, *Монголын цахилгаа холбоо компаний* – Одгэрэл заан гэх мэт олныг дурьдаж болно.

Эдгээр нэр хочууд ард түмний ердийн яриа хэлэнд ижил нэртэй, цол хэргэмтэй, алдар цуутай бөхчүүдийг хооронд нь ялган танихад түгээмэл хэрэглэгдсээр өнөөг хүрчээ. Хоч нэрийн агуулгаас үзвэл тухайн бөхийн бие бялдар, хүч чадал, гадаад төрх, зан авир төдийгүй овор хэмжээ, эрхэлдэг ажил алба, барилдааны арга барил, дархан мэх зэргийг гол шалгуур болгон янз бүрээр нэр хоч тогтоон өгсөөр иржээ. Хэдийгээр янз бүрийн нэр хоч байвч тэдгээр нь ерөнхийдөө тухайн нэг бөхийг ямагт хүндэтгэн алдаршуулж ирсэний илэрхийлэл. Жишээ нь: Мангар гэдэг үг шууд утгаараа онцгүй мэт боловч, энэ нь Санжаа зааны хэмжээлшгүй их бяр хүч, гүдэсхэн занг нийт олноор бахархсан шинжээрээ олонд түгсэн байдаг бол Лувсанжамц арслан аатай, бянтай, барилдаан сайтай, хэлсэн амандаа хүрдэг тэрхүү чанараараа олонд “Аат” хэмээн нэрлэгдсэн ажгуу.

Зарим бөх нэрээрээ бус хочоороо алдаршсан байдаг. Энд Их Монгол, Боохой, Тэмээ өргөдөг, Накат, Буханхүү, Молиго бүргэд, Дэрэн бор гээд л олон бөхийг нэрлэж болно. Мөн нэг бөх олон хочоор ард олны дунд алдаршисан тохилдол цөөнгүй. Тухайлбал, Хамбын бор буюу Урт гарт Лхагва, Мангар буюу Том Санжаа, Босоо буюу Жаахан Дамбий, Чойнзон заан “Ишгэн”, “Гогцоо”, “Бусгаа” гэх зэргээр нэрлэгдэж явсан гэдэг. Эндээс бөхийн хоч нэр нь шинж чанар, утга агуулгын хувьд олон талыг хамарсан өргөн ойлголт болох нь мэдэгдэнэ.

Дээр дурьдсан нэр хочоос биеийн онцлог байдал буюу тухайн бөхийн онцлог шинжээс үүдэлтэй хоч давамгайлах байр суурийг эзлэж байна. Энд цохон тэмдэглүүштэй зүйл гэвэл хоч нэр бүхий улсын цолт бөхчүүдээс “заан цолтнууд” бусдыг бодвол илүү олон тоотой (43%) байгаа нь сонирхолтой юм.

Төгсгөлд нь тэмдэлэхэд ард түмэн, бөхчүүд маань ойр дотно харилцан, бие биенээ төвөггүй ойлгож, сэтгэл санаа нь өөдрөг явахад

нөлөөлж байсан нэгэн хүчин зүйл нь хоч нэр байжээ. Өөрөөр хэлбэл, ардаас бөхөө дээдлэн хүндэтгэж буйн нэгэн илрэл нь тухайн бөхөд ямарваа нэг нэр хоч тогтоон өгдөг явдал байсан гэж үзэж байна.

Ашигласан ном зохиол.

А. Судалгааны ном зохиол:

1. Баасандорж А . Монголын үндэсний бөхийн бага нэвтэрхий толь. УБ., 2000.
2. Бат-очир Ц . Үндэсний бөх 50 жил . УБ., 1975 .
3. Бат-очир Ц . Бадаргуулт төрийн эрийн 3 наадам (1890 –1900) дөтгөөр дэвтэр , 2 боть. УБ ., 2000.
4. Бат-очир Ц . Эрийн 3 наадам (1909 - 1921) 5-р дэвтэр, УБ., 1996.
5. Баясгалан Г . Үндэсний бөхийн арслангууд . УБ., 1992.
6. Болдбаатар Ж . Дайчин вангийн домогт хүчитнүүд. (Дэд дэвтэр). УБ.,1996
7. Гоохүү Ш . Цагийг эзэлсэн их аваргууд . УБ., 2000.
8. Дамдин Ж . Монгол бөх . УБ., 1971.
9. Лувсанжав Чой . Эрдэнэ вангийн домогт хүчтэн . УБ., 2000.
10. Монгол бөх наадам . УБ., 2001, 1-р улирал.
11. Монгол бөх наадам . УБ., 2001, 2-р улирал.
12. Монгол бөх наадам . УБ., 2001, 3-р улирал.
13. Мягмар Ш . Дамдин гарлаа давлаа . УБ., 1995.
14. Ням-осор Л . Халх бөхийн барилдаан . УБ.,1984.
15. Ням-осор Л , Батсүх Б . Монгол бөхийн хөгжилт . УБ.,1989.
16. Үндэсний бөх 55 жил . УБ., 1975.
17. Үндэсний бөх 70 жил . УБ.,1991.
18. Цэвэл Я . Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1961.
19. Шагдаргочоо Д . Монголын бөх . УБ., 1960.

Б. Сонин сэтгүүл :

1. Бямба гариг . 2002, № 04.
2. 81-р суваг . 2002, № 41.
3. 81-р суваг . 2002, № 42.
4. 5 цагираг . 2002 . 5 . 22 , № 21.
5. Хувийн амьдрал . 2002 . 6-р сар , № 16.
6. Зууны мэдээ . 2002 . 7 . 9 , № 169.
7. Үнэн . 2002 . 7. 11 , № 136.

В. Тэмдэглэл :

1. Булган аймгийн Хишиг - өндөр сумын "Гандан Даржаалан" хийдийн лам өвөө Цэрэндагва болон эмээ Шарав нараас тэмдэглэн авсан болно (2002 оны 7 сарын 23.).
2. 2001 – 2002 оны хичээлийн жилийн хээрийн танилцах дадлагын явцад Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Бат–Очир арслангын гэгээн дурсгалт зориулан босгосон хөшөөг үзсэн юм. Уг хөшөөнд Бат – очир арсланг " Молиго бүргэд " хэмээх гэжээ (2002 .6. 28.).
3. Булган аймгийн Хишиг-Өндөр сумын харьяат бөх сонирхогч Сундуйжавын Батбаяраас тэмдэглэн авсан материал (2003. 2. 27.).